



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН РЕКТОРЫН
ТУШААЛ

2025 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/406

Улаанбаатар хот

Тэнхимийн эрхлэгчийн албан тушаалын
тодорхойлолт шинэчлэн батлах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.3.2, ШУТИС-ийн дүрмийн 4.9.11, 4.9.16 дахь заалтууд, ШУТИС-ийн мэргэжлийн тэнхимийн үйл ажиллагааг зохицуулах журам, Ректорын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн Албан тушаалын тодорхойлолт боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай” А/406 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Тус их сургуулийн мэргэжлийн тэнхимийн эрхлэгчийн албан тушаалын тодорхойлолтыг хавсралтаар баталсугай.

2. Энэ тушаал гарсантай холбогдуулан өмнө мөрдөж байсан Ректорын 2016 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/02 дугаар тушаалаар баталсан бүрэлдэхүүн сургуулийн салбарын эрхлэгчийн болон тэнхимийн эрхлэгчийн албан тушаалын тодорхойлолтыг хүчингүйд тооцсугай.

3. Энэхүү тушаалыг 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

РЕКТОР  Т.НАМНАН

367040847



АЖЛЫН БАЙР /АЛБАН ТУШААЛ/-ЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☒ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо: 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр: Шинжлэх ухаан, технологийн их сургууль (ШУТИС)

Нэгжийн нэр: Бүрэлдэхүүн, салбар сургууль

Албан тушаалын нэр: Бүрэлдэхүүн, салбар сургуулийн тэнхмийн эрхлэгч

Албан тушаалын ангилал, зэрэглэл: ПБ - 1

Ажлын цаг: Ажлын өдөр, 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил: СБД-ийн 8 дугаар хороо, ШУТИС-ийн хичээлийн төв байр

Хөдөлмөрийн нөхцөл: Хэвийн

Онцгой нөхцөл: Хамаарахгүй


II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Шинжлэх ухааны тодорхой чиглэлээр мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, инновацын ажил явуулах, материаллаг баазыг бэхжүүлэх, тэнхимийн хүний нөөцийн болон хөгжлийн бодлогыг төлөвлөн хэрэгжүүлэх, багш, ажилтны гүйцэтгэлийг үнэлэх ба гадаад, дотоод хамтын ажиллагаа, түншлэл, суралцагчийн хөгжлийн асуудлыг хариуцан тэнхимийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

Албан тушаалын зорилт:

1. Тэнхимийг хөгжүүлэх бодлого, стратеги, урт, дунд, богино хугацааны төлөвлөгөө, хөтөлбөр, төслийг бүрэлдэхүүн, салбар сургуулийн хөгжлийн бодлого, стратеги, зорилго, зорилттой уялдуулан боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах, үр дүнг үнэлэх;
2. Шинжлэх ухааны тодорхой салбараар мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг хөгжүүлэх, хэрэгжүүлэх, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулан явуулах, сургалтын чанарт



- хяналт тавьж, баталгаажуулах, сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх;
3. Багш, судлаачдын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжих, хурал семинар зохион байгуулах, шинэ технологи хөгжүүлэх, дамжуулах болон оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах бүрэлдэхүүн, салбар сургуулийн бодлогыг тэнхимд хэрэгжүүлэх;
 4. Суралцагчдын хөгжлийг дэмжих, эрдэм шинжилгээ, судалгаа, инновацын чадавхийг дээшлүүлэх, үйлчилгээний төрөл, хүртээмжийг нэмэгдүүлж, чанарыг сайжруулах бүрэлдэхүүн, салбар сургуулийн бодлогыг тэнхимд хэрэгжүүлэх;
 5. Тэнхимийн багшлах бүрэлдэхүүний хэрэгцээг тодорхойлох, төлөвлөх, бүрдүүлэлтийн судалгаа хийх, чадавхжуулах, мэргэжлийн хөгжлийг хангах, ачааллыг хуваарилах, гүйцэтгэлийг тооцож, үр дүнг үнэлэх, шагнал урамшуулалд тодорхойлох, хариуцлага тооцох, бүрэлдэхүүн, салбар сургуулийн хүний нөөцийн бодлогыг тэнхимд хэрэгжүүлэх;
 6. Тэнхимийн үйл ажиллагааны бүх чиглэлээр гадаад, дотоодын байгууллагуудтай хамтран ажиллах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, нийгмийн түншлэлийг хөгжүүлэх, нийгмийн болон мэргэжлийн үйлчилгээний төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх, чанарыг дээшлүүлэх болон нийгмийн хариуцлагын талаарх бүрэлдэхүүн, салбар сургуулийн бодлогыг тэнхимд хэрэгжүүлэх;
 7. Албан ажлын хүрээнд хийгдэх бусад үйл ажиллагаа;

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т, Хариуцан гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Тэнхимийг хөгжүүлэх бодлого, стратеги, урт, дунд хугацааны төлөвлөгөө боловсруулах; 2. Тэнхимийг хөгжүүлэх бодлого, стратеги, урт, дунд хугацааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах; 3. Тэнхимийн хичээлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө болон санхүүгийн жилээр гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах; 4. Жил бүрийн Тэнхимийн үйл ажиллагааны болон гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах; 5. Жил бүр сургуулийг хөгжүүлэх урт, дунд хугацааны болон жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний явц (PI), үр дүнг (KPI) урьдчилан тодорхойлсон үзүүлэлтүүдийн дагуу үнэлэх; 6. Тэнхимийн нөхцөл байдлын оношилгоо тогтмол хийх; 7. Тэнхимийн хэмжээнд эрсдлийн үнэлгээг жил бүр хийж, эрсдлийн удирдлагын төлөвлөгөө боловсруулан	Хөгжлийн урт, дунд хугацааны төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь Гүйцэтгэлийн төлөвлөгөөний явц (PI), үр дүнг (KPI) хэмжих үзүүлэлтүүдийн ахиц дэвшлийн хувь Эрсдлийн үнэлгээний ахиц дэвшлийн хувь Эрсдлийн удирдлагын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Т, Г, Ш



	хэрэгжүүлж, үр дүнг үнэлэх ажлыг Боловсруулсан, удирдан зохион байгуулах; 8. Тэнхимийн хэмжээнд хөгжлийн төсөл, хөтөлбөрийг боловсруулах, хөгжүүлэх, хэрэгжүүлэх, гэрээт ажил, төсөл гүйцэтгэх ажлыг удирдан зохион байгуулах; 9. Их сургуулийн эрэмбэ чансаа тогтоох, ахиц дэвшлийн үнэлгээ хийх, магадлан итгэмжлэлийн үйл ажиллагаатай холбоотойгоор Тэнхимд хийгдэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах; 10. Тэнхимийн хэмжээнд нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх, өгөгдлийн шинжилгээ, статистик, тайлан мэдээллийн боловсруулалт, шинжилгээг хийх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах; 11. Тэнхимийн үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах; 12. Тэнхимийн үйл ажиллагаанд оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч, дүгнэлт хийн, авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг удирдлагаар хангаж ажиллах;	хөгжүүлсэн хөгжлийн төсөл, хөтөлбөрийн тоо Гүйцэтгэсэн гэрээт ажил, төслийн тоо Хугацаандаа гарсан статистик тоо баримт, мэдээ, мэдээлэл, тайлангийн эзлэх хувь Тэнхимийн үйл ажиллагаа ISO 21001 болон бусад олон улсын стандартад нийцсэн байдал Оролцогч талуудын сэтгэл ханамжийн түвшин	Т, Г, Ш
2 дугаар зорилтын хүрээнд	1. Тэнхимийн хэмжээнд бүх шатны сургалтын үйл ажиллагааг сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, их сургуулийн сургалтын нэгдсэн хуанли, оюутны хичээл сонголт, хичээлийн хуваарийн дагуу зохион байгуулах; 2. Тэнхимийн хэмжээнд бүх шатны сургалтын элсэлт, төгсөлтийн үйл ажиллагааг удирдлагаар хангах; 3. Тэнхимийн хэмжээнд бүх шатны сургалтын үйл явц, суралцахуйн үр дүн, чанарыг үнэлэх, тасралтгүй сайжруулах; 4. Тэнхимийн хэмжээнд бүх шатны сургалтын хөтөлбөрийг шинээр болон шинэчлэн боловсруулах, хөгжүүлэх, хэрэгжүүлэх, үр дүнг үнэлэх; 5. Тэнхимийн хариуцан хэрэгжүүлдэг бүх шатны сургалтын хөтөлбөрийн боловсруулалт, хөгжүүлэлтийн ажлыг удирдан, зохион байгуулах; 6. Тэнхимийн хариуцан хэрэгжүүлдэг хөтөлбөрийн болон сургалтын үйл ажиллагааны чанар, үр дүнгийн үнэлгээ, шинжилгээг тогтмол хийх; 7. Тэнхимийн хэмжээнд зайн, цахим, цахим-танхим хосолсон, зэргийн бус,	Их сургуулийн сургалтын нэгдсэн хуанлийн бүрэн хэрэгжилт Элсүүлсэн оюутны тоо Мэргэжлээрээ ажиллаж буй төгсөгчийн эзлэх хувь Хариуцан хэрэгжүүлдэг хөтөлбөрүүдийн олон улс, үндэсний түвшинд магадлан итгэмжлэгдсэн байдал Хариуцан хэрэгжүүлдэг хөтөлбөрүүдийг шинэчлэн боловсруулсан байдал Тэнхимийн хэрэгжүүлдэг бүх шатны сургалтын хөтөлбөр, үйл	Т, Г, Ш



	ажлын байран дах сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй, чанартай, боломжит хувилбаруудаар зохион байгуулах; 8. Насан туршийн боловсрол, тасралтгүй хөгжлийг хангах урт, дунд, богино хугацааны мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтуудыг зохион байгуулах; 9. Гадаад хэл дээр хөтөлбөр хэрэгжүүлэх, хичээл заах, гадаад оюутан элсүүлэх ажлыг удирдан зохион байгуулах; 10. Докторын дараах судалгааны ажлыг дэмжих хөтөлбөр, төсөл, санал боловсруулах, хэрэгжүүлэх; 11. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн шинжилгээ, таамаглалыг тогтмол хийх; 12. Сургуулийн сургалтын үйл ажиллагаа, хөтөлбөрийн чанарыг шинэ шатанд гаргах олон улсын сайн туршлага, ололтыг нэвтрүүлэх, нутагшуулах бодлого, хөтөлбөр, төсөл, санал боловсруулах, хэрэгжүүлэх; 13. Тэнхимийн сургалт, судалгааны материаллаг орчин, мэргэжлийн лабораторийн үйл ажиллагаанд дотоод чанарын баталгаажуулалт, тасралтгүй сайжруулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх; 14. Ном, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн, материаллаг баазын хангамжийг сайжруулах;	ажиллагаа, чанартай холбоотой оролцогч талуудын сэтгэл ханамжийн түвшин Зохион байгуулсан богино хугацааны сургалтын тоо, түүнд хамрагдсан хүний тоо Зайн, цахим, цахим-танхим хосолсон, зэргийн бус, ажлын байран дах хичээл, сургалтын тоо, түүнд хамрагдсан суралцагчийн тоо Докторын дараах судалгааны ажлыг дэмжих хөтөлбөр, төсөлд хамрагдсан багш, ажилтны тоо Гадаад оюутны эзлэх хувь Гадаад хэл дээр хэрэгжүүлж буй хичээлийн эзлэх хувь Сургалт, судалгааны материаллаг орчин, мэргэжлийн лабораторийн үйл ажиллагаанд дотоод чанарын баталгаажуулалт хийсэн байдал	Т, Г, Ш
3 дугаар зорилтын хүрээнд	1. Шинжлэх ухаан, технологи, инновацын талаар гаргасан төрийн бодлого, зорилтууд, их сургууль болон бүрэлдэхүүн, салбар сургуулийн эрдэм шинжилгээ, судалгааны бодлого, төлөвлөгөөг тэнхимийн хэмжээнд хэрэгжүүлэх; 2. Тэнхимийн судалгааны тэргүүлэх чиглэл, хөгжүүлэх технологийн талаар баримтлах бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх, үр дүнг үнэлэх; 3. Олон улсын, бүсийн, үндэсний, салбарын, орон нутгийн хэмжээний төсөл, хөтөлбөр, судалгааны ажил, хөгжлийн болон эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг, уулзалт, сургалт, семинар, үзэсгэлэнд тэнхимийн багш, ажилтнуудыг оролцуулах, өөрсдөө санаачлан хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах;	Эрдэм шинжилгээний нэгдсэн хуанлийн бүрэн хэрэгжилт Төсөл, гэрээт ажил удирдсан багш, ажилтны тоо Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн багш, судлаачийн тоо Нэг багшид ноогдох WoS, Scopus-т бүртгэлтэй өгүүллийн дундаж тоо	Ш, Х




	4. Тэнхимийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг олон нийтэд таниулах, түгээн дэлгэрүүлэх, хэвлэн нийтлүүлэх, эрдэм шинжилгээний мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх ажлыг удирдан зохион байгуулах; 5. Тэнхимийн эрдэмтэн судлаачдын эрдэм шинжилгээ судалгааны ажлын явц үр дүн, оюуны бүтээлийг хэвлэн нийтлүүлэх, бүртгэлжүүлэх, оюуны өмчийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын механизмыг боловсронгуй болгох ажлыг удирдан зохион байгуулах; 6. Тэнхим, үйлдвэрлэл хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх, технологи дамжуулах, инновацыг нэвтрүүлэх, гарааны компани байгуулах ажлыг тэнхимийн хэмжээнд удирдан зохион байгуулах; 7. Тэнхимийн хэмжээнд шинээр буй болсон, баталгаажсан оюуны өмчийн бүртгэл мэдээллийг бий болгох, оюуны өмчийн тоо хэмжээг нэмэгдүүлж, гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, инновацын төсөл, гэрээт ажлын үр дүнг дээшлүүлэх; 8. Олон улс, улсын чанартай болон гадаадын их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагатай хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, техник, технологи хөгжүүлэх; 9. Тэнхимийн судалгааны чиглэлийн хүрээнд олон улсын, бүсийн, үндэсний хэмжээний мэргэжлийн байгууллага, холбоо, зөвлөлийн гишүүнээр элсэх, тэдний үйл ажиллагаанд оролцох, хамтын ажиллагааг хөгжүүлэх; 10. Тэнхимийн эрдэм шинжилгээ, судалгааг дэмжих санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	WoS, Scopus-т бүртгэлтэй нэг өгүүлэлд ноогдох дундаж эшлэлийн тоо WoS, Scopus-т бүртгэлтэй нийт өгүүлэлд гадаадын эрдэмтэд, байгууллагатай хамтарсан өгүүллийн эзлэх хувь Үндэсний болон олон улсын түвшинд магадлан итгэмжлэгдсэн нээлттэй, салбар дундын лабораторийн тоо Багш, судлаачийн тэнхимийн эрдэм шинжилгээ судалгааны үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн түвшин Инновац, энтепренершипийн сургалтанд хамрагдсан багш, судлаачдын тоо Инновацын төслийн тоо Үйлдвэрлэлд нэвтрүүлсэн технологийн тоо Лицензийн гэрээний тоо	
4 дүгээр зорилтын хүрээнд	1. Тэнхимийн хэмжээнд “Оюутны үйлчилгээний нэгдсэн хуанли”-г хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах; 2. Тэнхимийн оюутан, суралцагчдын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын чадавхыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх, эрдэм шинжилгээний хурал, семинар зохион байгуулах;	Оюутны үйлчилгээний нэгдсэн хуанлийн тэнхим дэх хэрэгжилтийн хувь Оюутан, суралцагчийн сэтгэл ханамжийн түвшин	Т, Г, Ш



	3. Их сургуулийн болон гадаад дотоод хувь хүн байгууллагын тэтгэлэг, кредитийн урамшуулалд Тэнхимийн оюутан, суралцагчдыг хамруулах, цар хүрээг нэмэгдүүлэхэд хамтран ажиллах; 4. Хариуцан хэрэгжүүлдэг хөтөлбөрийн оюутан, суралцагчдын сургуулийн орчин дах хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, ажил мэргэжлийн хөгжлийн төсөл хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах; 5. Хариуцан хэрэгжүүлдэг хөтөлбөрийн оюутан, суралцагчдыг тэнхимийн судалгааны төсөл, лабораториудын судалгаанд оролцуулах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах; 6. Хариуцан хэрэгжүүлдэг хөтөлбөрөөр суралцагч тусгай хэрэгцээт болон гадаад оюутнуудад чиглэсэн үйлчилгээг сайжруулах, тэдний сурах, судлах үйлд дэмжлэг үзүүлэх; 7. Хэв журам, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон харилцаа хандлагын асуудлаар хариуцан хэрэгжүүлдэг хөтөлбөрийн оюутан, суралцагчдад чиглэсэн арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах; 8. Хариуцан хэрэгжүүлдэг хөтөлбөрийн хүрээнд оюутан суралцагчдыг санал санаачлагыг дэмжсэн үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлэх, тэднийг хөгжүүлэн төлөвшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах;	Эрдэм шинжилгээний хурал, семинарт оролцсон оюутан, суралцагчийн эзлэх хувь Сургуулийн орчинд хөдөлмөр эрхэлсэн оюутан, суралцагчийн тоо Оюутан, суралцагчийн карьер хөгжлийн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь Судалгааны багт ажилласан ахисан түвшний оюутны тоо Тусгай хэрэгцээт болон гадаад оюутнуудын үйлчилгээний хүртээмж Оюутныг дэмжих, хөгжүүлэн төлөвшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	
5 дугаар зорилтын хүрээнд	1. Тэнхимийн хүний нөөцийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, чадварлаг, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэх, тогтвортой ажиллах нөхцөлөөр хангах чиглэлээр санаачлагатай ажиллах; 2. Тэнхимийн профессор, багш нарын хичээл хуваарилалтыг хийх, багц цагийн тооцоог хийх, гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх; 3. Тэнхимийн профессор, багш, ажилтнуудын залгамж халааг бэлтгэх, ажил хэрэгч, чадварлаг, бүтээлч, эвсэг хамт олон бүрдүүлэх; 4. Тэнхимийн хүний нөөцийн сургалт, хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг удирдан, зохион байгуулах; 5. Тэнхимийн багшийн мэргэжлийн болон багшлахуйн үр чадварыг хөгжүүлэх	Тэнхимийн багш, ажилтны сэтгэл ханамжийн түвшин Тэнхимийн хүний нөөцийн сургалт, хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь Гадаад, дотоодод богино хугацааны сургалт болон зэргийн бус хөтөлбөрт хамрагдсан багш, ажилтны тоо	Т, Г, Ш



	сургалт зохион байгуулах, шинээр орж байгаа багш, ажилтныг чиглүүлэх, дадлагажих хөтөлбөрт хамруулах ажлыг удирдан, зохион байгуулах; 6. Тэнхимийн багш, ажилтнуудын ажлын үр дүнг үнэлж дүгнэх, шагнал урамшуулалд тодорхойлох, хариуцлага тооцоход санал гаргах; 7. Тэнхимийн багш, ажилтнуудын цахим бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэн баяжуулахад шаардлагатай мэдээллээр удирдлагыг хангах, холбогдох мэдээ, судалгаа, тайлан гаргах; 8. Тэнхимийн багш, ажилтнуудын нийгмийн асуудал, эрүүл мэнд, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахад чиглэсэн боломжтой арга хэмжээг авч ажиллах;	Багшлах үр чадвар, заах арга зүйн сургалтад хамрагдсан багшийн тоо Гадаад, дотоодод дадлагажих хөтөлбөрт хамрагдсан багш, ажилтны тоо Тэнхимийн багш, ажилтны нийгмийн баталгааг хангах чиглэлээр санаачлан хэрэгжүүлсэн ажлын тоо	
6 дугаар зорилтын хүрээнд	1. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн гадаад харилцаа, хамтын ажиллагаа, нийгмийн түншлэл, нийгмийн хариуцлагын бодлого, стратеги, төлөвлөгөөг Тэнхимийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг удирдан, зохион байгуулах; 2. Тэнхимийн гадаад харилцааг өргөжүүлэх, үр өгөөжийг дээшлүүлэх; 3. Гадаад, дотоодын их, дээд сургууль, ажил олгогч, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй Тэнхимийн хэмжээнд хамтран ажиллах боломж нөхцөлийг судлах, санал хүргүүлэх, хүлээж авах, хамтарч ажиллах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах; 4. Төгсөгчидтэй тогтмол эргэх холбоотой ажиллаж, төгсөгчдийн холбоотой хамтын ажиллагааг хөгжүүлэх; 5. Олон улсын, улсын хэмжээний оюутны байгууллага, их сургууль болон бүрэлдэхүүн, салбар сургуулийн оюутны өөрийн удирдлагын болон сайн дурын байгууллагуудтай хамтарч ажиллах; 6. Тэнхимийн хэмжээнд олон талт түнштэй хамтарсан мэргэжлийн үйлчилгээг хөгжүүлэх ажлыг удирдан, зохион байгуулах; 7. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн маркетинг, олон нийттэй харилцах үйл ажиллагаа, мэдээлэл түгээн дэлгэрүүлэлтийн бодлого, стратеги, төлөвлөгөөг Тэнхимийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг удирдан, зохион байгуулах;	Нийгмийн түншлэл, нийгмийн хариуцлагын бодлого, стратеги, төлөвлөгөөг Тэнхимд хэрэгжүүлсэн байдал Гадаад харилцаа, хамтын ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь, үр өгөөж Олон талт түнштэй хамтран хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний тоо Хамтран ажилласан оюутны өөрийн удирдлагын байгууллага, мэргэжлийн, сайн дурын клубын тоо Төгсөгчдийн холбоотой хамтран хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний тоо Хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилтийн хувь Тэнхимийн	Т, Г, Ш



	8. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн цахим хуудас, сошиал сувгуудад Тэнхимийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллүүдийг тухай бүр шуурхай байршуулах, Тэнхимийн хэмжээнд мэдээллийн ил тод байдлыг хангах, түүхэн сан хөмрөг үүсгэх ажлыг удирдан зохион байгуулах;	хэмжээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн маркетинг, олон нийттэй харилцах үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн хувь	
7 дугаар зорилтын хүрээнд	1. Тэнхимийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах; 2. Монгол улсын хууль тогтоомж, дүрэм журам, их сургуулийн дүрэм, журам, эрх бүхий этгээдийн тогтоол, шийдвэр, тушаал, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах; 3. Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль, журам, стандарт, байгууллагын архивын ажлын үндсэн зааврын дагуу баримт бичгийг зохион бүрдүүлж, хөтлөх, хадгалах, ашиглах үйл ажиллагааг Тэнхимийн хэмжээнд нэгдсэн удирдлагаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавих; 4. Их сургууль болон бүрэлдэхүүн, салбар сургуулийн байгуулсан гэрээ, хэлэлцээр, санамж бичгийг Тэнхимийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах; 5. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн эрдмийн зөвлөл, захирлын зөвлөлийн үйл ажиллагаанд оролцон гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; 6. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн Захиралтай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт, Тэнхимийн үйл ажиллагааны тайланг хамт олонд тайлагнах; 7. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь чанартай гүйцэтгэх; 8. Тэнхимийн профессор, багш, ажилтнуудын өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар хангаж, ирц, ажлын цаг ашиглалт, ажлын ачаалал, зохион байгуулалтад хяналт тавих, ажлыг үнэлж, дүгнэх, шагнаж, урамшуулах, хариуцлага тооцох талаар санал боловсруулах; 9. Оролцогч талуудаас ирсэн өргөдөл гомдол, санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх; 10. Албан ажлын хүрээнд хийгдэх бусад үйл ажиллагаа;	Монгол улсын хууль, дүрэм, журам, дээд шатны байгууллагын шийдвэр, үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь Бүрэлдэхүүн, салбар сургуулийн эрдмийн болон захиргааны зөвлөлийн шийдвэр, үүрэг даалгаврын биелэлтийн хувь Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль, журам, стандарт мөрдөлтийн түвшин Ректорын өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн хувь Бүрэлдэхүүн, салбар сургуулийн Захиралтай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийн хувь Тэнхимийн үйл ажиллагааны тайланд хамт олны өгсөн үнэлгээ Тэнхимийн багш, ажилтны сэтгэл ханамжийн түвшин Хяналт, шинжилгээ, дотоод аудитын зөвлөмжийн хэрэгжилтийн хувь Санал гомдол шийдвэрлэлтийн хувь Авилгаас ангид, ёс зүйн болон хууль эрх зүйн зөрчилгүй ажилласан байдал	Г, Ш

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

ШУТИС-ийн ректорын 2022 оны 05 дугаар сарын 09-ны өдрийн 14 дугаар тушаалын хавсралт



Боловсрол	Доктор (Ph.D)-с доошгүй эрдмийн зэрэгтэй;	
Мэргэжил	Тухайн тэнхимийн сургалт, судалгааны аль нэг чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн;	
Мэргэшил		
Туршлага	- Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад 10-аас доошгүй жил ажилласан; - Багшлах болон эрдэм шинжилгээ, судалгааны ажлын дадлага, туршлагатай;	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	Сургуулийн ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах, боловсруулах, харьцуулалт хийх, нэгтгэх, дүгнэх, санал, зөвлөмж боловсруулах, гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах, дүн шинжилгээ хийх чадвартай байх
	Асуудал шийдвэрлэх	Хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбар боловсруулах, өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг байх, бүтээлч санаачилгатай ажиллах, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахих, ажлын цагийг баримтлан, харилцааны соёлыг эрхэмлэх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид шударга байх, байгууллага, хувь хүний нууцыг хадгалах
	Багаар ажиллах	Багаар ажиллаж, мэдлэг туршлага, ур чадвараа бусадтай хуваалцах, хамтран ажиллах, хамт олны эерэг нээлттэй уур амьсгалыг бүрдүүлэх, манлайлах
	Бусад	Сургуулийн ажлын дагуу хууль эрх зүйн үндэслэлтэй зөвлөгөө, мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх, компьютерийн өргөн хэрэглээний программ, мэдээллийн технологийн дэвшилтэт технологи ашиглах, төрийн албан хэрэг хөтлөлт, монгол хэл бичгийн найруулга, дүрмийн мэдлэгтэй байх, англи хэл эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ:

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:	
Бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирал	
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	Бусад харилцах субъект:
Тэнхимийн багш, ажилтнууд	ШУТИС-ийн захиргааны газар, алба, нэгжүүд, харьяалах сургуулийн нэгжүүд, бүрэлдэхүүн, салбар болон харьяа сургууль, хүрээлэнгүүд, холбогдох яам, агентлаг, их, дээд сургуулиуд, олон улсын байгууллага, төлөөлөгчийн газар, хамтран ажилладаг байгууллагууд, хувь хүмүүс

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ:


Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, баталсан:
---	---

ШУТИС-ийн ректорын 2025 оны 05 дугаар сарын 09-ны өдрийн 09 дугаар тушаалын хавсралт



Албан тушаалын нэр:

ШУТИС-ийн Захиргааны удирдлагын газрын дарга

 Б.Түмэндэлгэр

/гарын үсэг/

/эцэг, эхийн нэрний эхний үсэг, нэр/

2025 оны 05 дугаар сарын 09 ны өдөр

Байгууллагын нэр: Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургууль

Шийдвэрийн огноо, дугаар:



Албан тушаалын нэр: ШУТИС-ийн ректор

/гарын үсэг/

Т.Намнан
/эцэг, эхийн нэрний эхний үсэг, нэр/

2025 оны 05 дугаар сарын 09 ны өдөр